УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2020 оны 04 сарын 02-өдөр Дугаар А/122 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 2.7, 3.1.8, 4.2.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын эзэмшил, ашиглалтад хамаарах Наран, Улаанчулуутын төвлөрсөн хогийн цэгүүд дэх барилга байгууламжийн бүртгэл, ашиглалтын байдалд хяналт шалгалт явуулж, үнэлэлт дүгнэлт өгөх , нийслэлийн өмчид бүртгэлжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Шалгалтын үр дүн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд 2020 оны 04 дүгээр сард багтаан танилцуулахыг Ажлын хэсэг /Ц.Рэгзэдмаа/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

C:\Users\Gantuya\Desktop\УЖ 12\doc 2020\Тушаал 2doc.docx

1110370386

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
А/1122 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн дарга
Гишүүд	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг холбооны асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн
	Т.Энх-Амгалан	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	У.Ёндон	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч
	Б.Найрамдал	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын Улсын байцаагч
	В.Даваадорж	Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Нийтийн Хэв журмын газрын Тасгийн дарга, дэд хурандаа
	Б.Мягмаржав	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Гал түймрийн хяналтын Улсын ахлах байцаагч, хошууч
	Н.Болормаа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Наранцацрал	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн
	М.Пүрэвдорж	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Төвлөрсөн хогийн цэгүүдийн менежментийн албаны дарга
Нарийн бичгийн дарга	М.Энхтуяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Тооцооны нягтлан бодогч
	С.Мөнхбат	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын ахлах нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга

М.Энхтуяа
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Тооцооны нягтлан бодогч

С.Мөнхбат
Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын ахлах нягтлан бодогч

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн
А/1122 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГҮҮД ДЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН БАЙДАЛД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ, ӨМЧИД БҮРТГЭЛЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго.

1.1.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Хот тохижилтын газарт харьяалагдах Төвлөрсөн хогийн цэгүүд дэх нийслэлийн өмчид бүртгэгдээгүй байгаа барилга байгууламжын шалтгаан нөхцлийг тогтоох, өнөөгийн ашиглалт, эзэмшлийн байдалд хяналт хэрэгжүүлэх, хөрөнгийн эзэмшил, ашиглалттай холбоотой үүссэн зөрчил дутагдлыг арилгах, өмчид бүртгүүлэх бэлэн байдлыг хангуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа.

2.1.Хамрах хүрээ:

a) Сонгинохайрхан дүүргийн Наран, Улаанчулуутын хогийн цэг дэх барилга байгууламжийг анх ашиглалтад оруулсан, хүлээлгэн өгсөн, хүлээн авсан байгууллага, нэгж;
b) Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны холбогдох алба хэлтэс, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Төвлөрсөн хогийн цэгийн менежментийн алба/;
c) Төвлөрсөн хогийн цэгүүдэд үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд.

2.2.Хугацаа:

a) Хяналт шалгалтыг 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны хооронд зохион байгуулж, явц, үр дүн, санал дүгнэлтийг танилцуулна.
b) Өмчид бүртгүүлэх бэлэн байдлыг хангах, ажлыг холбогдох байгууллага, нэгжүүд 04 дүгээр сард багтаан хэрэгжүүлнэ.

Гурав. Хяналт, шалгалтын ажлын чиглэл:

3.2. Сонгинохайрхан дүүргийн Наран, Улаанчулуутын төвлөрсөн хогийн цэгүүд дэх бүртгэлгүй барилга байгууламж, хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэсэн эсэхийг болон өмчид бүртгэгдээгүй байгаа барилга байгууламжын шалтгаан нөхцлийг тогтоох,

3.2.Барилга обьектэд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, хуулийн этгээдийн хууль, эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт хэрэгжүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, эзэмшигч, ашиглагчийг тогтоох,

3.3.Барилга байгууламжийн хийц бүтээц, бүрэн бүтэн байдал, ашиглалтын хэрэгцээ шаардлагыг хангах эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид нийслэлийн өмчид бүртгүүлэх өмч хөрөнгийг тодорхой болгох, бүртгүүлэх бэлтгэл зохион байгуулалтыг хангах,

3.4.Байгууламжууд дахь цахилгаан хангамжийн эх үүсвэр, цахилгаан, гэрэлтүүлэг ашиглалтын зардал, төлбөр төлөлтийн байдал.

Дөрөв. Ажлын зохион байгуулалт.

4.1. Удирдамжийг холбогдох байгууллагуудын удирдлагуудад мэдээлж, ажлыг эхлүүлнэ.

4.2. Анх ямар эх үүсвэрээр хэдэн онд ашиглалтад орсон, ашиглагч, эзэмшигч байгууллага, хуулийн этгээдтэй хийсэн гэрээ, нөхцлийн талаархи мэдээллийг холбогдох байгууллагууд үнэн зөвөөр гаргаж, ажлын хэсгийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах.

4.3. Удирдамжийн 3-т заасан чиглэлүүдийн хүрээнд үзлэг шалгалт явуулахад хариуцсан байгууллага, нэгжүүдийн холбогдох албан тушаалтнууд газар дээр нь ажиллаж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.

Тав. Дүнг танилцуулах:

5.1. Ажлын үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд 2020 оны 04 дүгээр сард багтаан танилцуулна.

***